ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2023/13/-НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2023 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр<br>Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор Б.Цэвэлмаа<br>Утас 99026016 Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn<br>Аудитор М.Дөлгөөнбаяр<br>Утас: 85151215 Цахим хаяг: dulguunbayarkh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**/мянган төгрөг/**

| **Үзүүлэлт** | **2021.12.31** | **2022.12.31** |
|---|---|---|
| **Санхүүгийн байдлын тайлан** | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 149,602.51 | 157,206.39 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,181,887.63 | 1,386,308.31 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **1,331,490.14** | **1,543,514.70** |
| Нийт өр төлбөрийн дүн | | 204.60 |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,331,490.14 | 1,543,310.10 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,331,490.14** | **1,543,514.70** |
| **Санхүүгийн үр дүнгийн тайлан** | | |
| Үйл ажиллагааны орлогын дүн | 666,169.21 | 736,080.95 |
| Үйл ажиллагааны зардлын дүн | 478,311.26 | 520,761.00 |
| **Үйл ажиллагааны үр дүн** | **187,857.95** | **215,319.95** |
| Үйл ажиллагааны бус үр дүн | 0 | 0.00 |
| **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **187,857.95** | **215,319.95** |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,143,196.24 | 1,331,490.14 |
| Тайлант оны үр дүн | 188,293.90 | 211,819.96 |
| **Эцсийн үлдэгдэл** | **1,331,490.14** | **1,543,310.10** |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 402,201.08 | 371,725.07 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 327,926.08 | 371,725.07 |
| **Үйл ажиллагааны ЦМГ** | 74,275.00 | 0.00 |
| **Хөрөнгө оруулалтын ЦМГ** | -74,275.00 | 0.00 |
| **Санхүүгийн ажиллагааны ЦМГ** | - | 0.00 |
| **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | - | 0.00 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | |
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **315,400.00** | **364,049.90** |
| Урсгал зардал | 315,400.00 | 364,049.90 |
| Хөрөнгийн зардал | 0.00 | 0.00 |
| **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **315,400.00** | **364,049.90** |
| Улсын төсвөөс санхүүжих | | |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 315,400.00 | 363,549.90 |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 0 | 500.00 |
| Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл | 0 | |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитаар нийт 6.4 сая төгрөгийн алдаа[1], зөрчлийг арилгасан. Үүнд:

## Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 5.4 сая төгрөгийн хивгийг худалдаж авснаар тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайлан хэлбэлзлээс 0.05 сая төгрөгөөр зөрүүтэй, ХХОАТ-ын 1.0 сая төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалт "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 81.6 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 10.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 6 заалт 71.5 сая төгрөгийн албан шаардлага, 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

### 3.1 Төлбөрийн акт

- ✓ Дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.6-т "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингийн 25 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно. Улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн тооцох урамшууллын хэмжээг энэ журмын 4.5-д заасан аргачлалд тусгана". 4.11-т "Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажлаас чөлөөлөгдсөн Засаг даргын орлогчид үндэслэлгүйгээр 5.3 сая төгрөгийн тэтгэмж олгож төсөв хохироосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дунд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай оролцсон багш сурагчдад 0.4 сая төгрөг, тэмцээн уралдааны шагнал бэлэгт 2.0 сая төгрөг, ардын цолтон, амжилт гаргасан тамирчдад хүндэтгэл үзүүлэхэд 2.0 сая төгрөг нийт 4.4 сая төгрөгийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн

---

[1] Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4.-т "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Албан шаардлага**

- ✓ Жолоочийн замын хуудасгүй, жагсаалтаар 9.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байгаа нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнд 1.5 сая төгрөг, улс аймгийн аварга малчин, саальчин, спортын бага наадмын шагналд 7.0 сая төгрөг, сумын хүндэт иргэн, баг, байгууллагуудын шилдэг ажилчдад 1.7 сая төгрөг нийт 10.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь "Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4.-т "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Малжуулалтын гэрээний хугацаа дууссан 26.0 сая төгрөгийн 28 толгой малыг дараагийн айлд шилжүүлээгүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;" Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр малжуулах гэрээний 2.1 дэх хэсэгт малжуулалтаар авсан малыг гэрээний хугацааны дагуу тоо толгойгоор нь дараагийн өрхөд бүрэн хүлээлгэж өгнө" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй нь "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 131.9 сая төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй нь "Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бараа материалын дансанд бүртгэлтэй 25.6 сая төгрөгийн хөрөнгийг тоолоогүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Хууль тогтоомжтой холбоотой**

Илрүүлэлт: Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшин ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслийг тод энгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох ажлыг зохион байгуулах.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайшир сумын Засаг даргын Тамгын газар | 3 | 6.40 | 0 | 0.00 | 0.00 | 0.00 | 3 | 6.40 | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **6.40** | **0** | **0.00** | **0** | **0.00** | **3** | **6.40** | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

| **Зөрчлийн товч утга** | **Нийт зөрчил** | | **Үүнээс** | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцуулах албан шаардлага** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал** | |
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Албан тушаалтны тоо** | **Тоо** | **Дүн** |
| Тайшир сумын Засаг даргын Тамгын газар | 10 | 81.60 | 3 | 10.12 | 6 | 71.5 | 1 | - | - | - | - | - |
| Дүн | **10** | **81.60** | **3** | **10.12** | **6** | **71.5** | **1** | - | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын Тамгын газар | 2 | - | - | - | 1 | . | 1 | - |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын Тамгын газар | 1 | | | | 1 | | | |
| **Нийт дүн** | **3** | - | - | - | **2** | . | 1 | - |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | | Байгууллага, нэгжийн тоо | | Санал дүгнэлтийн хэлбэр |
|---|---|---|---|---|
| | | Аудитад ха | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | Төсвийн захирагчийн ангилал | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | - | - | - | 1 | - | - |
| | **НИЙТ** | **1** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** |

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР